

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны ... сар ... өдөр

Улаанбаатар хот

### ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН 2011 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хүний хөгжил сангийн 2011 оны төсвийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг нэмсүгэй:

***1/ 4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсэг:***

“4.4. Орон сууц худалдаж авсны төлбөрт 20,000.0 сая төгрөг”

**2 дугаар зүйл.** Хүний хөгжил сангийн 2011 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “... орлого 257,204.8 сая төгрөг” гэснийг “орлого 253,841.5 сая төгрөг” гэж, 3.4 дэх хэсгийн “... эх үүсвэр 470,896.4 сая төгрөг” гэснийг “эх үүсвэр 490,896.4 сая төгрөг” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “... 20,206.1 сая төгрөг” гэснийг “... 16,206.1 сая төгрөг” гэж, мөн зүйлийн 4.2 дахь хэсгийн “Бэлэн мөнгө 702,500.4 сая төгрөг” гэснийг “Бэлэн мөнгө 721,450.0 сая төгрөг” гэж, мөн зүйлийн 4.3 дахь хэсгийн “Оюутны сургалтын төлбөр 82,500.0 сая төгрөг” гэснийг “Оюутны сургалтын төлбөр 70,765.5 сая төгрөг” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2011 оны ... дугаар сарын ...-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ